



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

“Багахангай-2023” өвлийн өдөрлөг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил”-ийн хүрээнд “Багахангай-2023” өвлийн өдөрлөг арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулахыг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.

2.Арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, зохион байгуулахад зарцуулах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээнд зарцуулагдах 1,300,000 (Нэг сая гурван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Тус арга хэмжээнд байгууллагынхаа ажилтан, албан хаагчид, иргэдийг бүрэн хамруулан оролцоог хангуулж ажиллахыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч, хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.“Багахангай-2023” өвлийн өдөрлөг арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, санхүүгийн тайланг 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.


6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 09 сарын 09 -ны өдрийн 131 дугаар
Захирамжийн хоёрдугаар хавсралт



“БАГАХАНГАЙ-2023” ӨВЛИЙН ӨДӨРЛӨГ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Сур харваа (Баг)	ш	1-р байр	100,000	100,000
			2-р байр	80,000	80,000
			3-р байр	60,000	60,000
2.	“Олс таталт”-ын тэмцээн (Баг)	ш	1-р байр	100,000	100,000
			2-р байр	80,000	80,000
			3-р байр	60,000	60,000
3.	“Багахангай 2030” сэдэвт цасан хотхон	ш	1-р байр	100,000	100,000
			2-р байр	80,000	80,000
			3-р байр	60,000	60,000
4.	Цасан дээрх бүжиг (хос)	ш	1-р байр	50,000	50,000
			2-р байр	40,000	40,000
			3-р байр	30,000	30,000
5.	“Шилдэг байгууллага	ш	1	200,000	200,000
	Өргөмжлөл	ш	2	40,000	80,000
6.	Жааз	ш	12	15,000	180,000
7.	Нийт				1,300,000

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 09 -ны өдрийн 0131 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

“БАГАХАНГАЙ - 2023” ӨВЛИЙН ӨДӨРЛӨГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Нийслэл, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, “Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх” зорилтот жилийн хүрээнд иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, спортыг сурталчлахад өдөрлөгийн зорилго оршино.

ХОЁР. ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУГАЦАА

Өдөрлөгийн үйл ажиллагааг Биеийн тамир, спортын хороо зохион байгуулна. Арга хэмжээ 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Багахангай дүүргийн НААДМЫН ТАЛБАЙД зохион байгуулагдана.

ГУРАВ. ОРОЛЦОХ БАЙГУУЛЛАГА, ХҮМҮҮС

“Багахангай-2023” өвлийн өдөрлөг арга хэмжээнд Дүүргийн ААНБ-ын ажилтан албан хаагчид, 1,2 дугаар хорооны иргэд оролцоно.

Техникийн зөвлөгөөн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 14.00 цагт Биеийн тамир, спортын хороонд болно. Баг тамирчид мэдүүлэгтэйгээ ирсэн байна. (Олс таталтын тэмцээний жин үзнэ)

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ТЭМЦЭЭН, УРАЛДААН

Нээлтийн арга хэмжээ: 10.00 цагт эхэлнэ.

1. “Сур харваа” – Баг тус бүр 4 хүний бүрэлдэхүүнтэй (2 эрэгтэй, 2 эмэгтэй)
 2. “Олс таталт”-ын тэмцээн – Баг тус бүр 8 хүний бүрэлдэхүүнтэй (4 эрэгтэй, 4 эмэгтэй) тамирчид оролцоно. (Нийт жин 640 кг байна.)
 3. “Цасан дээрх бүжиг” тэмцээн – Байгууллага тус бүрээс 1, хороо тус бүр 2 хос оролцоно.
 4. “Хийн буудлага тэмцээн” – Баг тус бүрээс (2 эрэгтэй, 2 эмэгтэй) оролцоно
 5. “Багахангай 2030” сэдэвт цасан хотхон байгуулах – ААНБ, иргэд баг болж оролцоно.
- “Байгууллага бүр өөрийн спорт хамтлагийн үйл ажиллагааг сурталчлан оролцоно.
 - “Байгууллага, хороод ажилтан албан хаагч, иргэдийн эрүүл мэндийг хариуцна
 - Үдийн цайг нь эрүүл хүнсээр бэлтгэн оролцоно
- Жич: Цөөн хүнтэй ААНБ-ууд нэгдэж оролцож болно.

ТАВ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Тэмцээний төрөл тус бүрд эхний 3 байр эзлүүлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана. Нийлбэр дүнгээр нэгдүгээр байранд шалгарсан байгууллага хамт олныг Цом, Өргөмжлөл, Мөнгөн шагналаар шагнана.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО